

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 09 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
Үүрэг, даалгавар ХОЁР: Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламж, гүүрэн байгууламжийн арчлалт, хамгаалалтын зардлыг төсөвт тусгаж байх зохицуулалтыг хийж ажиллах.				
1	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламж, гүүрэн байгууламжийн арчлалт хамгаалалтын зардалд 2024 оны Орон нутгийн төсөвт 4,145,387.5 мянган төгрөг батлагдсан. Мөн дүүргийн 2025 оны төсвийн төсөлд 13,368,440.0 мянган төгрөгийн саналыг тусгаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 1/1761 тоот албан бичгээр хүргүүлсэн.			100
Үүрэг, даалгавар ГУРАВ: Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд гадна орчны тохижилтыг хийх, Захирагчийн ажлын алба, дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, орчны тохижилтыг хийлгүүлэх ажлыг зохион байгуулах.				
2	Чингэлтэй дүүргийн менежерийн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр баталсан "Тохилог Чингэлтэй" аяныг зохион байгуулах удирдамжийн хүрээнд хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 150 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зураглалаар тогтоосон орчны 50 метр хүртэлх талбайг тохижуулах, өнгө үзэмжийг сэргээх, засвар үйлчилгээ хийх, ногоон байгууламжийг бий болгох, шарилж зэрлэгийг зулгаах, хог хаягдлыг цэвэрлэх талаар үүрэг чиглэлийг өгч ажилласан. Тус аян нь 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулагдах бөгөөд тайлант хугацаанд 87 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аянд нэгдэж, орчны тохижилт хийсэн талаарх тайлан мэдээг ирүүлээд байна.			70
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн хэмжээнд хүүхдийн тоглоомын талбайн засвар, арчлалтыг хийж, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулах.				
3	Чингэлтэй дүүрэг дэх хүүхдийн тоглоомын талбайн өдөр тутмын цэвэрлэгээ, ногоон байгууламжит талбайн түүвэр цэвэрлэгээ, хогийн сав сулалт, явган хүний чулуун замын засвар, хайс хашлага угаалгын ажлуудыг дүүргийн “Чингэлтэй тохижилт			70

	үйлчилгээ” ХХК гүйцэтгэн ажиллаж байна. Дүүргийн 2, 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр ашиглалтад орж байгаа 2 тоглоомын талбайг тухайн хороод болон “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК-д 2024 оны 09 дүгээр сард багтаан хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.			
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Хорооллын дундах автозамын засвар, шинэчлэл хийх саналаа Замын хөгжлийн газарт хүргүүлэх.				
4	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эвдрэл, гэмтэл маш ихээр үүссэн авто зам болон засвар, шинэчлэл хийлгэх, шинээр тавих нийт 31 авто замын судалгааг нэгтгэн Нийслэлийн Замын хөгжлийн газарт дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 3/2317 дугаарын албан бичгээр саналыг хүргүүлсэн.			100
Үүрэг, даалгавар ДОЛОО: Нийслэлийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах				
5	Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр “Зөв дадал” ТББ-ын дэргэдэх “Цэлмэг өглөө” төвийн дэмжих бүлгийн иргэдтэй хамтран архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний хор уршгийг таниулах зорилгоор зан үйл засах спорт өдөрлөгийг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт Чингэлтэй дүүргийн архины хамааралтай 12 аавын төлөөллийг оролцуулж, хөдөлмөр заслын сургалт, аав хүүхдийн чөлөөт ярилцлага өрнүүлэх байдлаар сэтгэл засал, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Архины хор уршгийг таниулах, донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Бид хамтдаа” төслийн 2024 оны үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэн дүүргийн зорилтот бүлгийн 50 гэр бүлийг хамруулж, хороодын хамтарсан баг нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон төлөвлөгөө боловсруулж, ажил хөдөлмөрт зуучилдаг хувийн хэвшлийн байгууллагуудад иргэдийг ажлын байр, орлоготой болох чиглэлээр холбон зуучилж, хамтран ажиллаж байна. Амьдрах ухааны 12 модуль сургалтыг 7 хоног бүр 2 удаа зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг сэргээн засах төвд холбон зуучлан эмчилгээ хийгдэж байна. Дүүргийн 1-9, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хууль”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Хянамгай байя” арга хэмжээний хүрээнд тус хэлтсээс явган эргүүлийн 10 чиглэлд 20 алба хаагч 2024 оны 09 дүгээр сарын 13-наас 14-нд шилжих шөнө 23.00-05.00 цагийн хооронд хариуцсан нутаг дэвсгэрт эргүүл хяналт шалгалтыг зохион явуулж ажилласны үр дүнд; 1.Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, 36-р байрны 1 давхарт Pumba Pork ресторан нь шөнийн 03:00 цагт зөвшөөрөлгүй цагийн хуваарь хэтрүүлэн ажилласан. 2.Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, Харцага караоке нь зохих зөвшөөрөлгүй ажиллаж, 21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаа худалдан борлуулсан. 3.Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Премиум паласын 1 давхарт байрлах Сенатра караоке нь зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан.			70

	4.Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Coiner /Амрита/ баар нь цагийн хуваарь хэтрүүлж, 21 насанд хүрээгүй иргэнд архи согтууруулах ундаа худалдан борлуулсан. 5.Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Их тойруугийн 27 тоот СУ дэлгүүр нь 21 насанд хүрээгүй иргэнд архи согтууруулах ундаа худалдан борлуулсан зөрчлийг тус тус илрүүлэн нийт 4 шил архи, 23 ширхэг пиво хураан авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэсэн.			
Үүрэг, даалгавар АРВАН ДӨРӨВ: Дүүргүүд давс, бодис нөөцлөх ажлаа эрчимжүүлэх				
6	Дүүргийн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК 1500 тн давс, 1500 тн бодис, “Найши трейд” ХХК хариуцсан зам талбай болон авто замын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлэх зорилгоор өөрийн хөрөнгөөр 250 тн давс, 150 тн тусгай зориулалтын бодисыг тус тус худалдан авч нөөцөлсөн.			100
Үүрэг, даалгавар АРВАН ТАВ: “Сэлбэ дэд төв”-ийн газар чөлөөлөлттэй холбогдуулан эзэнгүй нохой, муур гаргах ажлаа шуурхай зохион байгуулах.				
7	Дүүргийн нутаг дэвсгэрт нохой устгалын чиглэлээр “Их булаг АТҮК” ХХК-тай гэрээтэй ажиллаж байгаа ба дүүргийн 14, 18 дугаар хороонд газар чөлөөлж байгаатай холбогдуулан 2024 оны 08, 09 дүгээр саруудад газар чөлөөлөлтийн бүсэд нохой устгалын ажлыг эрчимжүүлэн ажилласнаар нийт 926 золбин нохойг устгасан.			100
Үүрэг, даалгавар АРВАН ДОЛОО: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгддэг ажлын саналаа “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-д хүргүүлэх.				
8	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх төсөл арга хэмжээний нийт 9 саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 3/2327 дугаарын албан бичгээр “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-д хүргүүлсэн.			100
Үнэлгээний дундаж			88.7%	